

ДЭЛГЭРХАНГАЙ СУМЫН БЭЛГЭДЭЛ

СУМЫН СҮЛД



Дэлгэрхангай сумын сүлд нь эгнэгтийн орчил хөдөлгөөний илрэл цэнхэр хос цагираг хүрээн дотор мөнх хөх тэнгэр, Дэлгэрхангай уулыг дүрсэлсэн, дээд хэсэгт эрт, эдүгээ, ирээдүй гурван цагийн өнгөнд хүслийг хангагч чандмань эрдэнэ, 2 талд нь аймаг, сумын нэрийг бичиж, дунд хэсэгт ард иргэдийн ажил үйлс, аж амьдрал нь үргэлжид дардан байхыг бэлгэдэж өргөн, нарийн 3 шулуун зураас, доод хэсэгт ард түмний зочломтгой, найрсаг байдал, өсөн дэвжиж арвижихийг бэлэгдэн хадаг, алдартан гавъяатнуудын өлгий,

дуу, хуур, шүлэг, найраг, адуугаараа алдартайг бэлэгдэн морин хуурыг суурилуулан дүрсэлсэн байна.

Сумын сүлд нь хөх, цагаан өнгөний хосолмол илэрхийлэлтэй. Суурь өнгийг цагаанаар илэрхийлсэн нь шударга үнэнч, тууштай тогтвортой, сэвгүй ариун, бат бөх сэтгэлийн бэлгэдэл болно.

Хөх өнгө нь төгсөшгүй, дуусашгүй санааг илэрхийлж, алдар хүнд, мөнх тэнгэр мэт өнө мөнхөд оршин тогтнохын бэлгэдэл болно.

Дэлгэрхангай сумын сүлд нь сумын бэлгэдэл төдийгүй нутгийн түүхэн уламжлал, онцлог, бат бэх оршин тогтнохуйн бэлгэдэл, Дэлгэрхангайчуудын өнө мөнхийн цог хийморийг илэрхийлж байгаа ба хүн бүр сумынхаа бэлгэдлийг дээдлэн хүндэтгэж явах учиртай.

СУМЫН ТУГ



Дэлгэрхангай сумын туг нь мөнх хөх тэнгэр, газар дэлхийг бэлгэдэн хөх, ногоон өнгөтэй байна. Тугны ишин талын дээд буланд сумын сүлдээ байрлуулна. Тугны урт өргөн нь 1,5:0,8 метр байна.

Сумын сүлд, тугийн сумын байгууллага, аж ахуй нэгжүүд түр болон байнга, удирдлагын болон хуралдааны танхимын хойморт, сумын шинж чанартай арга хэмжээ, хурал, цуглаан өдөрлөг, хүндэтгэлийн арга хэмжээний нээлтийн үеэр байрлуулна.

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР